



# НЕМО МЭДЭЭ

## “БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЭЧЛЭЛ II” ТӨСЛӨӨС МЭДЭЭЛЖ БАЙНА

Энэхүү электрон сониныг Дэлхийн Байгаль Орчны Өдөр болон Монгол улсын Засгийн Газраас зохион байгуулж буй байгаль хамгаалах сарын ажлыг тохиолдуулан 2009 оны 6 дугаар сараас эхлэн ТА БҮХЭНД толилуулж байна.

### ЮУНЫ ТУХАЙ ӨГҮҮЛЭХ ВЭ?


Монгол Улсад байгаль орчны засаглалыг бэхжүүлэх, байгаль орчин, байгалийн нөөцийн менежментийг сайжруулах зорилгоор “Байгаль орчны шинэчлэл” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны тухай...

### “Байгаль Орчны Шинэчлэл-II” ТӨСӨЛ

<b>Хандивлагч:</b>	Нидерландын Вант улсын Засгийн газар
<b>Хамтран хэрэгжүүлэгч:</b>	Дэлхийн Банк – 2,6 сая
<b>Хэрэгжүүлэгч:</b>	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам – 2,4 сая
<b>Нийт төсөв:</b>	5 сая ам. доллар
<b>Хугацаа:</b>	2007-2010
<b>Төслийн зорилго:</b>	Монгол Улсад байгаль орчны засаглалыг бэхжүүлэх, байгаль орчин, байгалийн нөөцийн менежментийг сайжруулах”
<b>Үндсэн чиглэл:</b>	<b>Байгалийн нөөцийн менежмент</b> <b>Бохирдлын менежмент</b> <b>Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх</b>

Монгол улсын Засгийн газар болон Дэлхийн Банкны хооронд 2007 оны 07-р сарын 03-ны өдөр Нидерландын Вант Улсын Засгийн Газрын Итгэлийн Сангийн дэмжлэгээр “Байгаль Орчны Шинэчлэл-2” төслийг 2007-2010 онд хэрэгжүүлэх тухай 2,4 сая /2,438,748/ ам. долларын тусламжийн гэрээ байгуулагдсаны дагуу Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам төслийг 2 дахь жилдээ хэрэгжүүлж байна.

### Холбоо барих хаяг

<b>Төсөл Хэрэгжүүлэх Нэгж</b> Засгийн газрын III байр, 522 тоот, Утас: 976-11-325848, И-мэйл: <a href="mailto:nemo2@mne.gov.mn">nemo2@mne.gov.mn</a> ; Веб хуудас: <a href="http://www.worldbank.org/nemo">www.worldbank.org/nemo</a>	
Д.Идэвхтэн, Байгаль орчин, аялал жуулчлалын Дэд сайд, Төслийн үндэсний захирал	Р.Ариунбилэг, БОАЖЯ-ны хэсгийн зохицуулагч, Утас: 99082949, И-мэйл: <a href="mailto:r_ariunbileg@yahoo.com">r_ariunbileg@yahoo.com</a>
Тони Виттен, Төслийн менежер, Дэлхийн Банкны Ази, номхон далайн бүсийн салбарын байгаль орчны зөвлөх	А.Энхцэцэг, Дэлхийн Банкны хэсгийн зохицуулагч, Утас 99277307, И-мэйл: <a href="mailto:enkhee5mn@yahoo.com">enkhee5mn@yahoo.com</a>
	Д.Галхүү, Санхүүгийн ажилтан, Утас: 99082969, И-мэйл: <a href="mailto:galkhuud@yahoo.com">galkhuud@yahoo.com</a>



## ҮЙЛ ЯВДАЛ, МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ



1995 оноос эхлэн Дэлхийн Банк болон Монголын улсын Засгийн газрын байгаль орчны салбар дахь хамтын ажиллагааг бэхжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг нь үнэлж Дэлхийн Банкны Ази номхон далайн бүсийн байгаль орчны асуудал хариуцсан зөвлөх Тони Виттенг БОАЖЯ-аас “Байгаль орчны тэргүүний ажилтан” цол тэмдэгээр шагнасныг Дэд сайд Д.Идэвхтэн 5-сарын 26-нд гардуулж өглөө.

- “Байгаль орчны мастер төлөвлөгөө боловсруулах” чиглэлээр талуудын санал солилцох хэлэлцүүлэг 5-р сарын 28-нд Кемпински зочид буудалд боллоо.
- “Аялал жуулчлалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах” чиглэлээр талуудын санал солилцох хэлэлцүүлэг 6-сарын 3-ны өдөр яамны хурлын зааланд боллоо.
- “Агаарын бохирдлын нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн судалгаа”-ны танилцуулга /МУҮИС-ын цөмийн судалгааны төвийн секторын эрхлэгч О.Лодойсамба/ 6-р сарын 10-нд яамны хурлын зааланд болов.
- “Өрхөд суурилсан байгаль орчин, байгалийн нөөцийн менежментийн нийгэм эдийн засгийн нөлөөллийн судалгаа”-ны асуулгын туршилт Төв аймгийн Эрдэнэ суманд 5-р сард явагдаа.
- Жижиг төслийн мониторингийн багийн эхний ээлж өнөөдөр буюу 6-р сарын 12-нд замд гарлаа. Н.Эрдэнэсайхан, Б.Доржготов, Д.Галхүү нарын бүрэлдэхүүнтэй баг Төв аймгийн Лүн, Баянчандмань, Эрдэнэ, Батсүмбэр сумын нутгаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтийг хянах юм.

### Ойрын хугацаанд.....

- “Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын мастер төлөвлөгөө” боловсруулах багийн сонгон шалгаруулалт 6-р сард зохион байгуулагдана.
- “Өрхөд суурилсан байгаль орчин, байгалийн нөөцийн менежментийн нийгэм эдийн засгийн нөлөөллийн судалгаа”-ны санал асуулга Төв аймгийн Алтанбулаг суманд эхэлнэ.
- Химийн хорт болон аюултай бодисын эрсдлийн үнэлгээ хийх аргачлал боловсруулах ажил эхэлнэ.
- Байгаль орчны эрхзүйн шинэчлэлийн чиглэлээр хуулиудын хэлэлцүүлгүүд болно.
- Завхан, Дорнод, Булган, Говьсүмбэр аймгуудад жижиг төсөл боловсруулах, хэрэгжүүлэх асуудлаар олон нийтэд зориулсан нээлттэй сургалтууд хийгдэнэ.
- Зэрлэг ан амьтны менежментийг бий болгоход чиглэсэн ажлуудын гүйцэтгэгчийн сонгон шалгууралт зарлагдана.
- 9-р сард төслийн Гурван Талт Уулзалт болно.

## ҮЙЛ АЖИЛЛАГАА – 2009



### **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ХЭСЭГ**

#### **Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж орхигдсон газруудыг тоолж эхэллээ.**

БОАЖЯ-аас 2006 онд Монгол улсын хэмжээнд ашигт малтмалын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон, нөхөн сэргээсэн газрын тойм судалгааг гаргасан байдаг. Монгол улсын хэмжээнд уул уурхайн үйлдвэрлэл эрхэлдэг 331 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хийсэн судалгаанаас үзэхэд нийт 13718,5 га газар олборлолтод өртөн эвдрэлд орж, үүнээс 2553,2 га буюу 18.0%-д нь нөхөн сэргээлт хийсэн байна. Нөхөн сэргээлт хийлгүй орхисон талбайн хэмжээ 11200.0 га-д хүрчээ гэсэн дүгнэлтийг манай хяналт шалгалтын байгууллагууд гаргажээ.

Эвдрэлд орж орхигдсон газруудыг тоолж судалгаа гаргаснаар өмнө нь олборлолт хийж байсан эзнийг нь тогтоох, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлж хариуцлага тооцох, мөн нөхөн сэргээх ажлыг төлөвлөн хийх боломж бүрдэх юм. Энэ жил төвийн бүсэд уул уурхайн олборлолтын улмаас эвдрэлд орж орхигдсон газрын тооллогыг “Байгаль орчны шинэчлэл 2” төслийн хүрээнд нээлттэй тендерт шалгарсан “Эко Трейд” Компани хийхээр гэрээ байгуулж ажлаа эхлээд байна. Тооллогын баг хээрийн ажилд гарах бэлтгэлээ хангаж байна.

#### **Уул уухайн үйл ажиллагаанаас эвдрэлд орсон газарт биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийх аргачлал боловсруулж байна.**

Уул уухайн үйл ажиллагаанаас эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийх нэгдсэн аргачлал боловсруулагдан гарсанаар Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 309 дүгээр тогтоолоор баталсан “Ашигт малтмал олборлох үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, төрөл бүрийн ашигт малтмалыг олборлох, боловсруулахад өртөж эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн ажлын зардлын тооцоог бодитойгоор тооцож төлөвлөх, нөхөн сэргээлтийн ажлын барьцаа хөрөнгө төвлөрүүлэх зэрэг арга хэмжээг зохистой шийдвэрлэх асуудлууд нэг мөр шийдвэрлэгдэх юм.

Аргачлал боловсруулах ажлын хүрээнд орчин үеийн шинжлэх ухаан, техникийн ололтыг өргөн ашиглах, урд хийсэн судалгааны ажлын үр дүнд тулгуурлах, зарим нэмэлт судалгаа, туршилт хийх, гадаадын улс орнуудад хийгдэж буй нөхөн сэргээлтийн ажлын арга туршлагыг судалж харьцуулалт хийх, боломжтойг нь өөрийн орны нөхцөлд тохируулан ашиглах зэрэг ажлууд хийгдэнэ. Уг аргачлалыг боловсруулахад байгаль орчны хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг гардан боловсруулж байсан, байгаль орчны салбарт олон жил ажилласан, байгаль орчны талаар онол-практикийн өндөр мэдлэгтэй, ажлын дадлага туршлага бүхий эрдэмтэн, мэргэжилтнүүдийг оролцуулсан “Эко Сфера энд СЕК” компаниудын хамтарсан баг нээлттэй тендерт шалгаран ажлаа эхлээд байна.

#### **Байгаль орчин аялал жуулчлалын салбарын олон стандартуудыг цэгцэлж, бодлогын баримт бичиг боловсруулж байна.**

Одоогийн байдлаар байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамаарах үндэсний 160 гаруй стандарт байгаагийн зарим нь 1970-аад онд батлагдсан хуучин стандартууд байхын зэрэгцээ шинжилгээний аргын стандартууд нь давхардах, ялангуяа сүүлийн үеийн ISO орчуулгын стандартад нэр томъёог өөрөөр илэрхийлэх, орчуулга чанаргүй хийгдэх зэрэг дутагдалтай байдал байна. Иймд салбарын нийт стандартыг эргэж хянан, одоо байгаа стандартуудыг байгаль орчин, аялал жуулчлалын талаархи хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх, дутагдалтай байгаа болон шинээр боловсруулах шаардлагатай стандартын жагсаалтыг тодруулах, улмаар салбарын стандартын бодлогын баримт бичиг боловсруулан гаргах ажлыг “Байгаль орчны шинэчлэл-2” төслийн хүрээнд зарласан тендерт шалгарсан “Эко Ази” салбар дээд сургуулийн судлаач мэргэжилтнүүдийн баг БОАЖЯ болон Стандарт, хэмжил зүйн үндэсний төвтэй хамтран гүйцэтгэж байна.

### **Энэ жил 21 аймгаас 580 жижиг төсөл хүлээн авлаа.**

Өмнөх 3 удаагийн сонгон шалгаруулалтад нийт 1400 шахам төслийн санал ирсэнээс 100 гаруй төсөл шалгаран хэрэгжсэн бөгөөд байгаль орчны салбарт тулгамдаж буй бүхий л асуудлуудыг хамарсан байдаг. Төслийн хүрээнд олон тооны судалгааны тайлан, ном сурах бичиг, товхимол, гарын авлага хэвлэгдэж, телевиз радиогийн нэвтрүүлэг бэлтгэгдэн олны хүртээл болсон байна. Эдгээрийн дотор мэргэжлийн өндөр түвшинд хийгддэг судалгаа шинжилгээний аргазүйгээс аваад хүүхдүүдэд байгаль хамгаалах мэдлэг олгох танин мэдэхүйн зурагт ном хүртэл өргөн сэдэв, хүрээг хамарсан материалууд байгаа нь манай улсын байгаль орчны салбарын мэргэжилтнүүдийн чадавхийг бэхжүүлэх, бүх нийтийн экологийн боловсролыг дэмжих ажилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа нь дамжиггүй.

Зөвхөн тоон үзүүлэлтээр харахад өмнөх 3 удаагийн шалгаруулалтад бид нийт 750 орчим төслийн санал хүлээн авч байсан бол энэ жил 580 төслийн саналыг Монгол орны бүх аймгийн нутгаас хүлээн авсан нь олон нийтийн дунд байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцох идэвх санаачилга, төсөл бичих чадвар жил ирэх бүр дээшилж байгааг харуулж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас энэ жилийг “Орон нутгийн байгаль хамгаалагчдыг чадавхижуулах жил” болгон зарлаж байгаатай холбогдуулан жижиг төслийн тэтгэлэгт хөтөлбөрийг “Орон нутаг дахь байгаль орчны менементийг бэхжүүлэх нь” сэдвийн доор зарлан явууллаа. Энэхүү сэдвийн хүрээнд байгаль орчны үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт, мониторинг хийх, хамтын оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн нөхөрлөл хамтлаг, байгаль хамгаалагчдыг чадавхижуулах гэсэн чиглэлээр нийт 35 төсөл шалгаран хэрэгжиж байна. [Төслүүдийн мэдээллийг энд дарж үзнэ үү...](#)

### **Жижиг төслүүдийн хэрэгжилтэд БОАЖЯ-ны болон орон нутаг дахь БОАЖГ-ын мэргэжилтнүүд мониторинг хийнэ.**

Энэ жил яамнаас жижиг төслүүдийн үйл ажиллагааг байгаль орчны бодлого, шийдвэртэй нягт уялдуулах, үр өгөөжийг зохих ёсоор хүртэх, дэлгэрүүлэх, үргэлжлүүлэх явдлыг дэмжих үүднээс хэрэгжилтийг хянах үнэлэх ажилд салбарын мэргэжилтнүүд, ялангуяа орон нутаг дахь байгаль орчны ажилтнуудыг түлхүү оролцуулах бодлого барьж байна. Энэ зорилгоор жижиг төслүүдийн хэрэгжилтэнд мониторинг хийх баг 6-р сарын 03-нд албан ёсоор байгуулагдлаа. Мониторингийн багт БОАЖЯ-аас Дэд сайд, төслийн үндэсний захирал Д.Идэвхтэн, Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Дагвадорж, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ж.Нэргүй, Аялал жуулчлалын газрын орлогч дарга Э.Баттулга, Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Доржготов, Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын мэргэжилтэн Д.Шижир-Эрдэнэ, Төрийн захиргаа удирдлагын газрын мэргэжилтэн Д.Энэбиш нар орж ажиллахаар боллоо. Мониторингийн анхны томилолт 6-р сарын 12-нд төвийн бүсээс эхлэх бөгөөд нийт 5 чиглэлд явж ажиллах юм.

## ТӨСЛИЙН ЭХНИЙ ЖИЛИЙН ҮР ДҮНГИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЛИЙГ ЭНДЭЭС АВНА УУ - 2008



### БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХЭСЭГ

“Зэрлэг ан амьтны хууль бус худалдаанд хяналт тавих үндэсний баг” байгуулагдаж, туршилтын хяналт шалгалтуудыг хийлээ.

Зэрлэг ан, амьтны хууль бус худалдаатай хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын хамтын хүчээр шинэ арга механизмаар тэмцэх зорилгоор “Зэрлэг ан амьтны хуулийг хэрэгжүүлэх байгууллага хоорондын нэгж байгуулах” туршилтын төсөл хэрэгжлээ. Төслийн хүрээнд БОАЖЯ /CITES-ийн үндэсний зөвлөл, Тогтвортой хөгжил, стратеги төлөвлөлтийн газар/, УМХГ, Буянт-Ухаа дахь хилийн мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар болон түүний дэргэдэх “Ирвэс” шуурхай баг, Цагдаагийн ерөнхий газар /Хэрэг бүртгэх газар болон эргүүл хяналтын газрууд/-ын эрх бүхий ажилтнуудаас бүрдсэн хамтарсан баг байгуулагдаж, Улаанбаатар хотын ногоон бүс болон гол том захуудад 2008 оны 9, 12 сар, 2009 оны 1-р сард зэрлэг амьтан тэдгээрийн гаралтай эд бүтээгдэхүүний худалдаанд нийт 7 удаа хяналт шалгалт хийсэн байна. Энэ хугацаанд 19 зүйлийн хууль бус худалдаа, 15 хууль зөрчсөн зөрчил илрүүлж зохих арга хэмжээг авчээ. Түүнчлэн хамтарсан багийн гишүүд төслийн хүрээнд Лаос улсад туршлага судлах, танилцах аялалд оролцлоо. Цаашид байнгын ажиллагаатай хамтарсан багийг тогтвортой ажиллуулах хууль эрхзүйн орчинг бий болгоход чиглэсэн судалгааны ажил хийгдэж байна. [Төслийн тайланг энд дарж үзнэ үү.](#)



Photos by WCS Mongolia

Зэрлэг ан амьтны хууль бус агнуур ба худалдаатай тэмцэх олон нийтийн сургалт, сурталчилгааны компанит ажил явагдлаа.



Зэрлэг ан амьтны хууль бус агнуур болон худалдаатай тэмцэхэд олон нийтийн үзэл бодол, чиг хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалт сурталчилгааны ажлыг “Байгаль орчны шинэчлэл – 2” төслийн хүрээнд Дэлхийн Байгаль Хамгаалах Сантай хамтран хэрэгжүүллээ. Ан агнуурын тухай нийтийн дунд төлөвшсэн ойлголтуудыг тодорхойлох бүлгийн судалгаанууд болон [төслийн дэлгэрэнгүй тайланг энд дарж үзнэ үү.](#)



Жуулчдад зориулсан гарын авлага 6 хэл дээр хэвлэгдэн тараагдаж байна.

## “Монголын бурханы шашинтнуудын байгаль хамгаалах үйл ажиллагаа” гарын авлага



1990 оноос эдүгээ хүртэл Монгол орны байгаль хамгаалах салбарт олон байгууллага шинээр үүсэн бий болж энэ салбарт тулгамдаж буй олон чухал асуудлуудыг анхаарч ажилладаг ч тэдгээрийн дотроос Монголын нийгэмд хамгийн нөлөөтэй, өргөн цар хүрээтэй, салбарын нэг болох бурханы шашны сүм хийдүүдтэй байгаль хамгаалах чиглэлээр хамтарч ажилласан нь тун цөөхөн байдаг ажээ. “Байгаль орчны шинэчлэл 2” төслийн хүрээнд “Шашин ба байгаль хамгааллын холбоо - ARC” олон улсын ТББ, Монголын Бурханы Шашинтны Төв – Гандан Тэгчинлэн Хийдийн хамтран бүтээсэн энэхүү гарын авлага нь Монголын бурханы шашны зан үйл хийгээд тэдгээрийн байгаль хамгаалах гүн утга агуулга, холбоо харилцааны тухай ойлголтыг уншигчдад өгнө.

## Монгол орны биологийн төрөл зүйлийн мэдээллийн сантай боллоо.


Лондонгийн Зоологийн Нийгэмлэг Монгол улсын үндэсний их сургуулийн биологийн тэнхимтэй хамтран “Байгаль орчны шинэчлэл-1” төслийн хүрээнд “Монгол орны биологийн төрөл зүйлийн мэдээллийн сан” буюу датабанкийг боловсруулан хөхтөн амьтан, загас, хэвлээр явагчид, хоёр нутагтны бүх мэдээллийг нэгтгэн оруулсан юм. 2008 онд датабанкинд монгол оронд тохиолддог 485 зүйл шувууны анхан шатны мэдээллийг шинэчлэн боловсруулан нэмж оруулсан бөгөөд 2010 он гэхэд шувууны мэдээллийн санг дуусгаснаар Монгол орны бүх сээр нуруутан амьтдын мэдээллийн сан бий болох юм. Тус мэдээллийн сан нь Монгол орны биологийн төрөл зүйлийг хамгаалах төлөвлөгөө боловсруулахад үндсэн суурь болох бөгөөд Зүйлүүдийн тархалт: Хамгааллын төлөвлөгөөний эмхтгэл: Зүйлүүдийн хамгаалагдсан байдал: Устахад хүргэж буй хүчин зүйл: Популяцийн чиг хандлагын талаарх мэдээллийг тус тус агуулжээ. Монгол орны биологийн төрөл зүйлийн датабанкийг бүрэн хэмжээгээр нь Бүс нутгийн улаан жагсаалтын олон улсын вебсайтад байршуулан, түүнийг БОАЖЯ-ны вебсайтад холбосон бөгөөд мэдээллийг дараах холбоосоос харж болно. ([www.regionalredlist.com](http://www.regionalredlist.com)).



**Монгол орны хэвлээр явагчид болон хоёр нутагтны улаан жагсаалт”, “Монгол орны хэвлээр явагчид болон хоёр нутагтныг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөний хураангуй”-г шинэчлэн боловсруулж Англи, Монгол хэл дээр хэвлэгдлээ.**

Монгол орны биологийн төрөл зүйлийн ONLINE мэдээллийн санг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний арга хэрэгсэл болгон ашиглаж болно! Үүний тулд энэ холбоосоор орно уу. [http://www.regionalredlist.com/geog\\_search/geog\\_search.html](http://www.regionalredlist.com/geog_search/geog_search.html)

## Усны химийн шинжилгээний нэгдсэн аргачлалтай боллоо.



Усны чанарын талаархи баталгаатай, нарийвчлал сайтай үнэн зөв мэдээг гарган авах үндэс болсон усны химийн шинжилгээний уг нэгдсэн аргачлал нь гадаргын усны чанарын хяналт-шинжилгээний ажилд туршин нэвтрүүлж, ашиглаж ирсэн аналитик арга ажиллагаанд үндэслэсэн бөгөөд үүнийг орчин үед дэлхий нийтэд байгалийн цэвэр ус болон хаягдал бохир усны химийн задлан шинжилгээний практикт өргөнөөр ашиглаж байгаа нойтон химийн болон багажит шинжилгээний бусад аргаар баяжуулж, гидрохимийн болон бохирдлын нийтлэг 40 гаруй үзүүлэлтийг тодорхойлох 60 гаруй аргыг нэгтгэж оруулсан. **Хэнд зориулагдав:** Энэхүү аргачлал нь усны чанарын хяналт-шинжилгээний болон усны бохирдлын хяналтын байгууллага, лабораториуд, тэдгээрийн инженер, техникийн ажилтанд зориулагдсан бөгөөд уг номыг усны химийн задлан шинжилгээ хийдэг сургалт, үйлдвэрлэл, судалгаа шинжилгээ, хяналтын нийт лабораторийн химич, шинжээч судлаачид, оюутан сурагчид гарын авлага болгон ашиглаж болох ажээ.

## 2008 оны Байгаль орчны жижиг төслийн тэтгэлэгт хөтөлбөрт 37 төсөл хамрагдлаа.

Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх, ард иргэдийн оролцоонд тулгуурласан байгалийн нөөцийн менежментийг бий болгох, иргэд, олон нийтийг байгаль хамгаалах үйлсэд татан оролцуулахад чиглэсэн Засгийн газрын бодлого, “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”-ийг заалтыг хэрэгжүүлэхэд “Байгаль орчны шинэчлэл” төслийн хүрээнд 2004 оноос хойш зохион байгуулж буй жижиг төслийн тэтгэлэгт уралдаан тодорхой дэмжлэг болж байгааг дурьдах нь зүйтэй. Өнгөрсөн жилийн сонгон шалгаруулалтыг 2007 оны 11-12 сард олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлан нийт 355 төслийн санал хүлээн авсанаас нийт 290,711 ам.долларын өртөгтэй 37 төслийг шалгаруулан хэрэгжүүллээ. Жижиг төслүүдийн мониторингийн [тайланг энд дарж үзнэ үү](#). Төслүүдийн хэрэгжилтийн тайлан, үр дүнгийн тухай мэдээллийг энд дарж үзнэ үү. [www.forum.mn](http://www.forum.mn)

## Байгаль орчны хууль эрхзүйн орчинг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэв.

Байгаль орчны яамны хэрэгжүүлэх хэсгийн энэ жилийн төлөвлөгөөнд “Байгаль орчны хууль эрхзүйн орчинг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанууд” гэсэн багц мөнгийг суулгаж өгсөн нь нэлээд үр өгөөжтэй ажил боллоо. Энэ үйл ажиллагааг ерөнхийд нь нэг багц болгон төлөвлөсөн байсан нь байгаль орчны салбарын хууль эрхзүйг боловсронгуй болгоход чиглэсэн ажлуудыг яамны үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Дэлхийн Банктай зөвшилцөн цаг тухай бүрд нь тодорхойлон хэрэгжүүлэх боломжтой байснаараа онцлог байлаа. Энэ ажлын хүрээнд дараах хууль эрхзүйн шинэчлэлийн ажлууд хийгдэв.

1. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүсийн тухай хуулийг шинэчлэн боловсруулах ажилд Олон улсын байгаль хамгаалах холбооны (IUCN) зөвлөхийн өгсөн санал дүгнэлтийн [тайлан](#). Немо 1 төслийн хүрээнд гарсан [зөвлөмж](#).
2. Оюу Толгой төслийн уул уурхайн олборлолт болон боловсруулалтын ажлын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд олон улсын экспертийн хийсэн хөндлөнгийн үнэлгээний [тайлан](#)
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулинд оруулах нэмэлт өөрчлөлтийн [санал, үзэл баримтлал](#).
4. Ашигт малтмалын нөөцийг олборлох, баяжуулахад үүсэх хохирлын экологи, эдийн засгийн үнэлгээ, экологийн хохирол тооцох аргачлал”-д өгсөн олон улсын зөвлөхийн [санал дүгнэлт](#)
5. Био аюулгүй байдлын тухай сургалтын хөтөлбөр, гарын авлагууд
6. “Шинжлэх ухааны зорилгоор ан амьтан барих, тэмдэглэх заавар журам”

## ДЭЛХИЙН БАНКНЫ ХЭРЭГЖҮҮЛСЭН ХЭСЭГ 2007-2009


Эхний жилд ДБ-аас хэрэгжүүлж буй хэсэгт дараах ажлууд хийгдлээ.

- Улаанбаатар хотын усны ай сав газарт үнэлгээ хийх,
- Говийн бүсийн байгалийн нөөцийн стратеги,
- Агаарын бохирдлын мониторингийн протокол,
- Бохирдлын зэрэглэл тогтоох хөтөлбөр,
- Өрхийн төсөв/амьжиргааны түвшний судалгаанд байгаль орчин, байгалийн нөөцийн модуль нэмэх судалгаа
- Байгаль орчны төсвийн зардалд хийх тойм, дүн шинжилгээ,
- Байгаль орчны салбарын донор байгууллагуудын байгаль орчны салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн тухай цахим хуудас – [ДОМО.МН](http://ДОМО.МН)

### Байгаль орчны салбарын мастер төлөвлөгөө

Байгаль орчны салбарын урт хугацааны бодлогын хөтөлбөр, мастер төлөвлөгөөбловсруулахад холбогдох салбарын бодлого боловсруулагчид, эрдэмтэн, мэргэжилтнүүдийг оролцуулан хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох чиглэлээр санал солилцохоор Байгаль орчны Шинэчлэл” төслийн санхүүжилтээр БОАЖЯ-аас цуврал хэлэлцүүлгийг 3 удаа хэлэлцүүлэг зохион байгууллаа.

### Говийн Бүсийн Газрын Доорхи Усны Үнэлгээ



Монгол орны ашиглаж болох боломжит усны нийт нөөц 34.6 км куб, үүний 70 гаруй хувийг гадаргын, 30 хврэхгвй хувийг газрын доорхи ус тус тус эзэлдэг. ...

Говийн бүс нь өргөн уудам газар нутагтай, хүн ам багатай, зам харилцаа муутай боловч нүүрс, зэс зэрэг ашигт малтмалаар баялаг юм. Өмнөд говийн бүсийн (ӨГБ) эдийн засгийн хөгжил нь Монголын Засгийн газрын нэн тэргүүний асуудал юм. Говийн Бүсийн ба Өмнөд Говийн Бүсийн Хөгжлийн Нэгдсэн Төлөвлөгөөнд (ӨГБХНТ) зориулан Бүсийн Байгаль Орчны Үнэлгээний (ББОУ) бэлтгэл ажил хийх замаар Дэлхийн Банк Говийн Бүсийн Хөгжлийн Стратегид (ГБХС) дэмжлэг үзүүлж байна. Хур тунадас, гадаргын ус хязгаарлагдмал нутагт ус гол чухал нөөц юм.

Энэхүү тайлан Говийн Бүсийн Хөгжлийн Стратеги (ГБХС), Бүсийн Байгаль Орчны Үнэлгээ (ББОУ), Өмнөд Говийн Бүсийн Хөгжлийн Нэгдсэн Төлөвлөгөөний (ӨГБХНТ) суурь баримт болох ба Өмнөд Говийн Бүсийн одоогийн болон ирээдүйн усны нөөц, усны хэрэгцээг тодорхойлно. Эдгээр нь байгаа мэдээ мэдээлэл дээр тулгуурласан ба эдийн засаг, дэд бүтцийн хөгжилт, байгаль орчны хамгаалалд усны нөөцийн хөгжилт, менежмент дэмжлэг үзүүлж чадахыг батлах замаар санал дэвшүүлж байна.

ӨГБ-ийн усны нөөцийн хөгжилт нь үндэсний усны нөөцийн стратегийн нэг хэсэг бөгөөд усны нөөцийн менежментийг үндэсний хууль тогтоомж, дүрэм журам, зохицуулалт, байгууллагын бүтэц, хүний нөөцийн чадавхид тусгаж өгдөг. Иймээс тайланд үндэсний усны нөөц, Монгол орны ус хэрэгцээний хэсгийг багтаасан билээ.

## Туул голын эхэн хэсгийн эдийн засгийн үнэлгээ





Бид юү гаргаж үзүүлэх гэж зорьж байна вэ гэвэл

Улаанбаатар хотын усан хангамжийг тогтвортой байлгахын тулд Туул голын эхэн хэсгийг хамгаалахад зөрцуулах хөрөнгийн эдийн засгийн үр өгөөж . . .

... ба үүнийг хийхгүйгээс учрах эдийн засгийн алдагдлын хэмжээг үзүүлэх

Ургамлын бүс бүслүүрүүд болон газар ашиглалтын явц байдлыг судлах ,Газар, нөөц баялаг ашиглагч нарыг тодорхойлох , Газар, нөөц баялагийн ашиглалтын эдийн засгийн түвшин, үнэ цэнийн талаарх шуурхай асуулга , Нөөцийн хэрэглээ, ашиглагч болон газрын хэмжээ (га) –р эдийн засгийн үр ашгийг тооцоолон гаргах зорилгоор өгөгдлийн дүн шинжилгээ хийх зэрэг ажлууд хийхдээ Шведийн Ус цаг уурын хүрээлэнгийн боловсруулсан HBV загварыг ашиглан УБ хотын дээд хэсэгт ус хураах сав газарт 25 жилийн хугацаанд өдөр бүрийн голын усны урсацын симуляци хийж , өдөр бүрийн хур тунадас, температур болон боломжит ууршилтийн өгөгдлүүдийг загварчлалын орцод ашигласан байгаа



## УБ хотын усан хангамж Туулын голын сав газрын эхэн хэсгээс хамаарч байна

- Голын ай сав дахь экологийн, ургамлын нөмрөгийн, газар ашиглалтын өөрчлөлтүүд нь голын адаг хэсгийн усны нөөц, чанар, урсацанд их нөлөөтэй байна
- Гүний худаг, усны шугам хоолой болон хүний гараар бүтсэн усны бусад байгууламжууд нь УБ хотын усны хангамжийн чухал хэсэг юм
- Гэхдээ голын ай савын экосистем нь усны гол эх үүсвэр бөгөөд иймээс нүдний цөцгий мэт хайрлан хамгаалах ёстой
- Усны хагалбарын янз бүрийн менежментийн нөхцөлд голын доод хэсэгт усны хангамж яаж өөрчлөгдөх нь вэ гэдгийг харуулахыг зорилго болгов.

## Гурван хувилбар байна:

- *Одоогийн байдал үргэлжилсээр байвал:* газрын доройтол ихэссээр
- *Бүх хамгаалалтыг болиулбал:* экосистем хурдан доройтож, байгалийн нөөц баялаг шавхагдана
- *Хамгаалалтыг сайжруулбал:* газрын болон нөөц баялагийн ашиглалт тогтвортой
- Хувилбар бүрд эдийн засгийн үнэлэмж голын эхэн хэсгийн экосистемийг ашиглагч болон доод хэсгийн усны хэрэглэгчид хэрхэн өөрчлөгдөж байгааг үзүүлсэн.

## NEMO I – ХОЛБООСУУД...

Дэлхийн Банкны хэрэгжилтээр NEMO I төслийн хүрээнд хийсэн судалгааны тайлангуудыг доорх хаягаар татаж авна уу.



[http://siteresources.worldbank.org/EXTEAPREGTOPENVIRONMENT/Resources/Silent\\_Steppe\\_mongolian.pdf?resourceurlname=Silent\\_Steppe\\_mongolian.pdf](http://siteresources.worldbank.org/EXTEAPREGTOPENVIRONMENT/Resources/Silent_Steppe_mongolian.pdf?resourceurlname=Silent_Steppe_mongolian.pdf)



[NEMO I төслийн үр дүнгийн тухай мэдээллийг энд дарж үзнэ үү.](#)

[NEMO I төслийн хүрээнд хэрэгжсэн жижиг төслүүдийн үр дүнгийн мэдээллийг энд дарж үзнэ үү.](#)